



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**САЙХАН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
АРДЧИЛСАН НАМД**

2024.08.07 № ГНАГ-2024/11-УТА-НА-30  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн

018021007

тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.

### Дүгнэлт

Ардчилсан намын Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сайхан сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр ( .....<sup>4</sup>..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сайхан сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

САЙХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР




# САЙХАНЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

2024 он

ДЭД ХЭСЭГ

**УРИА: САЙХАНЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА**

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөрийн зорилт нь эдийн засаг, нийгэм, засаглалын гурван тулгуурт бодлогыг хэрэгжүүлэн, төрөлжсөн эдийн засагтай, чанар, хүртээмжтэй нийгмийн суурь үйлчилгээг үзүүлсэн, шударга засаглал бүхий бүтээлч иргэдтэй жишиг сум болгоход оршино.



## НЭГ. ЭДИЙН ЗАСАГ

### 1.1. Аж үйлдвэр


- 1.1.1. Цемент-Шохойн үйлдвэрийг түшиглэн бетон, төмөр хийц, барилгын материалын үйлдвэрийг ашиглалтад оруулах замаар аж үйлдвэрийн төв болгон хөгжүүлэх бодлогыг баримталж ажиллана.
- 1.1.2. Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээг түшиглэн төмөр хайлуулах үйлдвэрийг хувийн хэвшилтэй хамтран байгуулна.
- 1.1.3. Жижиг дунд үйлдвэрлэгч нарыг бодлогоор дэмжиж, бодит дэмжлэг үзүүлнэ.


### 1.2. Хүнс хөдөө аж ахуй

- 1.2.1. Малын үүлдэр угсааг сайжруулж, нийт малд өндөр ашиг шимт болон нутгийн шилмэл үүлдрийн малын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.
- 1.2.2. Нийтийн эзэмшлийн ухаалаг системтэй худгийг зайлшгүй шаардлагатай газруудад нэмж гаргах асуудлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.2.3. Хадлан, дарш бэлтгэх, тэжээлийн үйлдвэрлэл эрхлэхийг бодлогоор дэмжиж, малчдыг хадлангийн техник хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 1.2.4. Малчдын бэлчээрт ойрхон тариалангийн талбайг тусгаарлах хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж, тариалан эрхлэгч нартай хамтран тариалангийн талбайг хашлага, хаалттай болгох ажлыг зохион байгуулна.
- 1.2.5. Төмс хүнсний ногоо тариалагчдыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж, борлуулалтыг нэмэгдүүлэхэд бодлогоор дэмжинэ.
- 1.2.6. Өвөл, зуны хүлэмж барих ажлыг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.

### 1.3. Дэд бүтэц, аялал жуулчлал

- 1.3.1. Хүүхдийн паркийг олон улсын жишигт нийцсэн “Бахархлын гудамж”, “Байгууллагуудын нэрэмжит гудамж” бүхий “Цэцэрлэгт хүрээлэн”-г шинэчлэн барьж байгуулах ажлыг төр, хувийн хэвшил, олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.
- 1.3.2. Сайхан сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд “Шинэ суурьшлын бүс”-ийг тусгаж шинэчлэн боловсруулна.
- 1.3.3. Хөтөл хотыг тэлж хөгжүүлэх бодлого, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд “Амар тайван чуулган”-ы ойролцоох газарт инженерийн шугам татаж, барилгажих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.3.4. Ахмадууддаа зориулсан “Ахмадын өргөө”-г барьж байгуулах санхүүжилтийг улс, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлж, хэрэгжүүлнэ.
- 1.3.5. Мэдээллийн технологи харилцаа холбооны хамрах хүрээг тэлж, өндөр хурдны интернэтийн хурдыг өргөтгөх ажлыг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй оператор компаниудтай хамтарч ажиллана.
- 1.3.6. Гэр хорооллыг дэд бүтцийг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.




- 
- 1.3.7. Бүх орон сууцны дээвэр болон гадна фасадын засварын ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж гүйцэтгэнэ.
  - 1.3.8. Наадмын талбайг шинэчлэн засварлах ажлыг олон нийтийн санал санаачилгад үндэслэн шийдвэрлэнэ.
  - 1.3.9. Жимстэй хороолол руу 500 метр инженерийн шугам татах ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж гүйцэтгэнэ.
  - 1.3.10. Номгон тосгоны 1.2 км сайжруулсан шороон замыг хатуу хучилттай болгох ажлыг үргэлжлүүлнэ.
  - 1.3.11. Гэр хороолол болон Номгон тосгонд гэрэлтүүлэг хийж, аюулгүй орчин бий болгох ажлыг үргэлжлүүлнэ.
  - 1.3.12. Сайхан сумын хэмжээнд камержуулалтыг нэмэгдүүлж, аюулгүй орчин бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
  - 1.3.13. Овоот, Дөмбөн хорооллын инженерийн шугамын өргөтгөлийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж, улирал харгалзахгүй цэвэр ус хэрэглэх боломжийг нэмэгдүүлнэ.
  - 1.3.14. Спортын ордныг 2025 онд ашиглалтад оруулахад шаардлагатай хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох байгууллагад уламжилна.
  - 1.3.15. Худалдаа, үйлчилгээ, бизнес эрхлэгчдийн ажиллах таатай орчин бүрдүүлж шинээр Худалдааны төв байгуулах саналыг УИХ-ын гишүүдэд уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулж, шийдвэрлүүлнэ.
  - 1.3.16. Номгон тосгоны уурын зуухны менежментийг оновчтой төлөвлөж, гэр хороололд дулааны шугам татах ажлыг санаачлан, ашиглалтад оруулна.
  - 1.3.17. Номгон тосгоны төвийн үерийн хамгаалалтыг засварлан шинэчилнэ.
  - 1.3.18. Номгон тосгоны 12 айлын орон сууцны фасадыг засварлах санхүүжилтийг шийдвэрлэн хэрэгжүүлнэ.
  - 1.3.19. Номгон тосгонд нэн шаардлагатай байгаа Хүн эмнэлгийн барилгыг барих саналыг холбогдох байгууллагад уламжилж улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулах ажлыг зохион байгуулна.

## **ХОЁР. НИЙГЭМ**

### **2.1 Эрүүл мэнд**

- 2.1.1. Эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг орон сууцаар хангах ажлыг холбогдох байгууллагатай хамтарч зохион байгуулна.
- 2.1.2. Эрүүл мэндийн даатгалаас олгогддог эмийн хөнгөлөлтийг тэгш, хүртээмжтэй олгох асуудлыг холбогдох байгууллагатай хамтарч шийдвэрлэнэ.
- 2.1.3. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах аян өрнүүлж, халдварт, халдварт бус өвчлөлийг бууруулах ажлыг зохион байгуулна.
- 2.1.4. Сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг орчин үеийн стандарт шаардлагад нийцүүлэн үе шаттайгаар шийдвэрлүүлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжлан хөрөнгө оруулалтуудыг шийдвэрлүүлнэ.
- 2.1.5. “Явуулын эмнэлэг”-ийн үйлчилгээг нэвтрүүлж, иргэдийг 2 жил тутамд эрүүл мэндийн үзлэгт хамруулна.

- 2.1.6. Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, эмийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаад, дотоодын ижил төстэй эмнэлгүүдэд давтан сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран үе шаттайгаар зохион байгуулна.
- 2.1.7. Олон нийтийн оролцоонд тулгуурлан “Архидалттай тэмцэх” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.1.8. Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн халамж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.



## 2.2 Боловсрол


- 2.2.1 Цемент-Шохойн үйлдвэрийн сургалтын төвийг түшиглэн МСҮТ байгуулах саналыг холбогдох байгууллагад уламжилна.
- 2.2.2 Овоот, Дөмбөн, Жимстэй хороололд амьдарч буй сурагчдад зориулж сургуулийн автобусаар үйлчлэх боломжийг бүрдүүлж, бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.2.3 Шилдэг багш, суралцагчдыг гадаад, дотоодын сургуулиудад суралцуулах, дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.2.4 “Оюунлаг Сайханчууд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.2.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд иргэний нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлсэн үйлчилгээг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.2.6 Сайхан сумаас улсын болон олон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцож буй хүүхэд, залуучуудыг бодлогоор дэмжин ажиллана.
- 2.2.7 Сургуулийн дотуур байрыг шинээр барих ажлыг улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ.

## 2.3 Хөдөлмөр эрхлэлт

- 2.3.1 “Өрх бүр-Ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.3.2 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, “Хоршоо хөгжүүлэх сан”-г түшиглэж ажлын байр шинээр бий болгох бодлого баримтална.
- 2.3.3 Зорилтот бүлэг болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийг ажлын байраар хангах төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.3.4 “Хоршоо хөгжүүлэх сан”-аас санхүүжүүлэх зээлийн 30 хүртэлх хувийг зорилтот бүлэгт бизнесийн зориулалтаар олгох бодлого баримталж, сонгон шалгаруулалтыг ил тод, цахим болгох ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.3.5 Удаан хугацаагаар гэртээ хүүхэд асарч, ажил эрхлээгүй эмэгтэйчүүд, ганц бие эцэг, эхчүүдийг нийгмийн амьдралд татан оролцуулах, боломжит ажил үйлчилгээг туслан гүйцэтгүүлэх, ажлын уян хатан нөхцөл бүхий цагийн ажлаар хангах талаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамран, бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.3.6 Эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах төрийн бус байгууллагуудыг бодлогоор дэмжиж ажиллана.

## ГУРАВ. ЗАСАГЛАЛ

- 3.1. Үе үеийн Засаг дарга нарын “Зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн залгамж халааг бэхжүүлнэ.
- 3.2. Хөтөл хотын хилийн цэсийн асуудлыг шат шатны холбогдох байгууллагуудад уламжилж, хот төлөвлөлт, өргөжин тэлэх боломжийг бүрдүүлнэ.
- 3.3. Цемент-Шохойн үйлдвэртэй орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр нийгмийн хариуцлагын гэрээг байгуулж хамтран ажиллана.
- 3.4. Сууц өмчлөгчдийн холбоодыг үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон зорилтот бүлгийн өрхөд зориулж түрээсийн байрны үйлчилгээ нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3.6. “Хашаандаа сайхан амьдаръя” хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрх бүрийг ногоон байгууламж хийх нөхцөл бололцоог ханган бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.7. Гавшгай багийн төвийг Овоот хороололд байгуулж өрхийн эмнэлэг, хүүхдийн цэцэрлэг, цагдаагийн пост байгуулах ажлыг холбогдох байгууллагуудад уламжилж, шийдвэрлэнэ.
- 3.8. Төрийн захиргааны албан хаагчдыг ард, иргэд, олон нийт үнэлдэг системийг бий болгож, хариуцлагыг сайжруулна.
- 3.9. Гадаад орнууд болон бүс нутгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн, ижил түвшний аймаг, бүс, мужтай холбоо тогтоож, хамтран ажиллана.



## САЙХАН СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО